



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2017 оны 11 сарын 06 өдөр

Дугаар 24

Сүхбаатар

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйл, 35 дугаар зүйлийн 35.1.2, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, 7.1.6, 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Алтанбулаг сумын Засаг даргын Тамгын газрын дарга Ү.Янжиндуламын Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд ирүүлсэн өргөдөл, гомдлыг магадлан шалгах ажлын хэсгийг байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Ёндонжамц

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хууль, эрх зүйн хэлтсийн дарга,  
Төрийн албаны зөвлөлийн салбар  
зөвлөлийн гишүүн

М.Нямсүрэн

-Аймгийн шүүхийн Тамгын газрын дарга  
Төрийн албаны зөвлөлийн салбар  
зөвлөлийн гишүүн

Б.Ариундэлгэр

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хүний нөөцийн бодлого хариуцсан  
мэргэжилтэн, Төрийн албаны  
зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн  
бичгийн дарга

2. Өргөдөл гомдлыг зохих журмын дагуу шалгаж дүгнэлт санал боловсруулан Төрийн албаны салбар зөвлөлд 2017 оны 11 дугаар сарын 09-ны дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч / Д.Ёндонжамц /-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ө.СУВДАА